

БАТЛАВ
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
 Я. Содибаатар
 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ, ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

А/А	Нэгдсэн арга хэмжээний нэр		2021 он											
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг, ам эхгүйн нэгж, байгууллага айл өрхийн тал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	[Red]											
2	Өвөлжилт, хаваржилт хундрах болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		[Dark Blue]									[Dark Blue]		
3	Шар усны үеэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				[Yellow]									
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							[Green]						
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таныулах өдөрлөг				[Blue]									
6	Гэмшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												[Purple]	
7	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				[Dark Blue]									

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД *С. Соговбалор* СОДБААТАР
2020 оны 12 дугаар сарын 12 өдөр

**"ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОЛОН УЛСЫН ӨДӨР"-ИЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангах, олон нийтийг аюулгүй амьдрах арга ухаанд сургаж, дадлагажуулах, гамшгийн эрсдэлийг бууруулахын ач холбогдлыг хүүхэд, залууст таниулан мэдүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоол нь эрх зүйн үндэс болно.

2.2. Өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулахад дээрх хууль тогтоомж, энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Энэхүү өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд иргэд олон нийтийн оролцоог хангах, болзошгүй гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгаа, дадлага сургалтыг зохион байгуулна.

2.4. Ард иргэдэд гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, талаарх мэдээ, мэдээлэл, иргэдэд зориулсан зөвлөмж, сурталчилгаа, явуулах, гарын авлага, видео шторкыг албаны www.nema.gov.mn цахим хуудаснаас татаж авна.

Гурав. Хугацаа, хамрах хүрээ

3.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг 10 дугаар сарын 13-нд зохион байгуулна.

3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ард иргэд, их дээд болон ерөнхий боловсролын сургуулийн оюутан, сурагчдад чиглэгдэнэ.

Дөрөв. Зохион байгуулагдах үйл ажиллагаа

4.1. Олон улсын өдрийг тохиолдуулан Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль сурталчлах өдөрлөгийг зохион байгуулах.

4.2. Иргэд, олон нийтэд "Бэлэн бай", "Хэн ч, Хэзээ ч, Хаана ч Бэлэн" сургалтын багцаар танхимын сургалт болон дадлага сургуулийг зохион байгуулах.

4.3. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, сурагчдад "Аюулгүй амьдрах ухаан" сэдэвт танхимын болон дадлага сургуулийг зохион байгуулах.

4.4. Гэр хорооллын айл өрхүүдэд болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах.

4.5. Төрийн болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, ард иргэдэд чиглэсэн танхимын сургалт зохион байгуулах.

4.6. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр "Тамшигт тэсвэртэй дэд бүтэц" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулах.

4.7. Зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2021 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын урьдчилан сэргийлэх, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний

enkhmaanema4@gmail.com цахим хаягаар гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

**Тав. Өдөрлөгийн арга хэмжээний үр дүн,
зардал**

5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

5.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан өдөрлөгийн талаар дүнг Гамшгаас урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор танилцуулна.

5.3. Өдөрлөгийн арга хэмжээг явуулахад шаардлагатай зардлыг тухайн шатны Засаг даргын тамгын газрын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал, Онцгой байдлын газар, хэлтэс тус тус санхүүжүүлнэ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР